



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Зам засвар арчлалтын төрийн өмчит хувьцаат 20 компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар зарим шийдвэрлэх асуудал, нийтлэг зөрчил дутагдал байгааг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

1.1.Автозам, засвар арчлалтын компаниудыг улсын авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхдээ бэлэн байдлын түвшин буюу суурь нормоор санхүүжүүлж чадахгүй, автозамын их болон дунд хугацааны засвар, хөрөнгө оруулалтын асуудлыг орхигдуулж байгаа нь зах зээлийн зарчимд нийцэхгүй, компанийн үйл ажиллагаа өргөжин сайжрах боломжийг хязгаарлаж байгааг тооцож бэлэн байдлын түвшин буюу суурь нормоор санхүүжүүлэх системд шилжих асуудлыг судалж шийдвэрлэх;

1.2.Автозам, засварын арчлалтын санхүүжилтийн хэмжээ, хуваарийг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хугацаатай нийцүүлэн баталж байх;

1.3.Төрийн өмчийн зам, засвар арчлалтын компаниудын хариуцан ажиллаж байсан замыг хэсэгчлэн хувийн хэвшилд шилжүүлэх тохиолдолд төрийн өмчийн асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас санал авч зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж байх;

1.4.Төрийн өмчит зам, засвар арчлалтын 15 компанийн санхүүгийн тайланд урт хугацаат ер төлбөрөөр бүртгэсэн, 2009 онд Кувейтийн сангийн хөрөнгөөр бий болсон, ашиглалтын хугацаа дууссан, 5,218.6 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлүүлэх;

1.5.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас 2019 онд төрийн өмчийн зам, засвар арчлалтын 20 компанид үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн, тусгай зориулалтын, үнэ үнэлгээгүй, 42 ширхэг тээврийн хэрэгслийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр, зөвшөөрөл, бүртгэл, хяналтгүйгээр ашиглаж байгааг онцгой анхаарч хөрөнгийг үнэлж бүртгэхэд шаардлагатай анхан шатны баримт, материалыг үнийн саналын хамт Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж шийдвэрлүүлэх.

2.Автозам, засвар арчлалтын төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1.Төрийн өмчийн зам, засвар арчлалтын компаниудын 2012 онд Төрийн өмчийн хороо (хуучин нэрээр)-ны батлагдсан дүрэм болон хувьцааны тоо, үнэд зохих өөрчлөлт ороогүй байгаа тул Компанийн тухай хууль, “Авто зам, зам байгууламжийг барих, засварлах” тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны чиглэл, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлах;

2.2.Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г хугацаанаас нь өмнө цуцлах, тэтгэмж олгохдоо ажилласан хугацааны хөрөнгө, мөнгөний ашиглалт, зарцуулалтыг нарийвчлан тооцож үр дүнг баталгаажуулсны үндсэн дээр шийдвэр гаргаж байх.

3. Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа), Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

